ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 18 өдөр Дугаар 4/03 Сайншанд

Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олгох
салбар, чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь хэсэг, Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны а/361 дүгээр тушаалаар батлагдсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хоршоо хөгжүүлэх сангаас орон нутагт олгох төслийн чиглэлүүдийг хавсралт ёсоор баталсугай.

2.Нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тухайн жил олгохоор хэлэлцэж байгаа сангийн хөрөнгийн тавин хувиас ихгүй байхаар тогтоосугай.

3. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулж иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 6/17 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

462501304:1

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт

ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛД ЗӨВЛӨЛ ОЛГОХ ЧИГЛЭЛҮҮД

1. Хөдөө аж ахуй газар тариалан
   - 1.1 Арьс шир, нэхий, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэл
   - 1.2 Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах, даршлах
   - 1.3 Тэжээлийн ургамал тариалах
   - 1.4 Мод үржүүлэг, үр үрсэлгээ
   - 1.5 Байгалийн шимт бүтээгдэхүүн үйлдвэрлэл
   - 1.6 Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /гахай, тахиа, шувуу, мал аж ахуй үржүүлэх/
   - 1.7 Мал эмнэлэг үржлийн үйл ажиллагааг дэмжих
2. Хөнгөн үйлдвэрлэл
   - 2.1. Мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл
   - 2.2. Үйлдвэрлэлийн техник, машиг тоног төхөөрөмж
   - 2.3. Сав баглаа боодол үйлдвэрлэл
   - 2.4. Шахмал түлшний үйлдвэрлэл
   - 2.5. Барилга барилгын материал, сууц үйлдвэрлэл
   - 2.6. Хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрэл
3. Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл
   - 3.1. Мах, махан бүтээгдэхүүн боловсруулах цех
   - 3.2. Гурил, гурилан бүтээгдэхүүн боловсруулах цех
   - 3.3. Цэвэр ус үйлдвэрлэл
   - 3.4. Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл
   - 3.5. Байгалийн гаралтай эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл
4. Ахуй үйлчилгээний салбар, үйлчилгээ
   - 4.1. Үсчин, гоо сайхан
   - 4.2. Гар утас засвар
   - 4.3. Цахилгаан хэрэгслийн засвар
   - 4.4. Алт, мөнгөн эдлэл хийх
   - 4.5. Оёдол
   - 4.6. Фото зураг, Хэвлэл мэдээлэл, эх бэлтгэл
   - 4.7. Гутал засвар
   - 4.8. Бэлэг дурсгал, гар урлал
   - 4.9. Зочид буудал, зоогийн газар
   - 4.10. Кофе шоп, кафе үйлчилгээ
5. Авто тээвэрийн үйлчилгээ
   - 5.1. Авто засвар, оношилгоо
   - 5.2. Авто граш, авто угаалга
   - 5.3. Зорчигч тээврийн үйлчилгээ

-o0o-